



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/1481

Улаанбаатар хот

Төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцах их эмч, эм зүйч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний нэр, мэргэшлийн чиглэл, сургалтын төлбөрийн хэлбэр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын "Журам батлах, зардлын жишиг тогтоох тухай" 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ын 15.17.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын "Эрүүл мэндийн ажилтны 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай" 2024 оны А/125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцах их эмчийн нэрс /271/, суралцах мэргэшлийн чиглэл, сургалтын төлбөрийн хэлбэрийг нэгдүгээр, сувилагч, бусад мэргэжилтний нэрс /541/, суралцах мэргэшлийн чиглэл, сургалтын төлбөрийн хэлбэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төрөлжсөн мэргэшлийн сургалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, улсын төсвийн санхүүжилтээр суралцах эмнэлгийн мэргэжилтний сургалтын зардлыг 2024-2025 оны төгсөлтийн дараах сургалтын зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН

141242188